

ХӨРГӨЛТ / АГААРЖУУЛАЛТЫН СИСТЕМИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАДАЛ ЗУРШИЛ

ЗӨВ

- Аюулгүй орчинд, байнга зөв арга барилаар ажиллах;
- Ямар нэгэн засвар үйлчилгээ хийх эсвэл аливаа системийг хэрэглээнээс халахаасаа өмнө бодисыг байнга юулж авч байх;
- Хэрэв боломжтой бол эргүүлж боловсруулсан хөргөх бодисыг дахин ашиглаж байх;
- Бохирдсон хөргөх бодисыг тусад нь хадгалж, устгах;
- Системийг хөргөх бодисоор дахин цэнэглэхээс өмнө цоорхой байгаа эсэхийг шалгаж, засварлаж байх. Ганц л газар цоорсон байх гэж бодож болохгүй;
- Хөргөх бодис шилжүүлдэг хоолойг цэвэрлэх шаардлагыг багасгах зэргээр хөргөх бодистой зөв харьцаж сурах;
- Хөргөх бодис агуулах зориулалттай нэг удаа ашиглах бортогыг хаяхаасаа өмнө бүрэн хоослох;
- Хөргөлт, агааржуулалтын системийг байж болох хамгийн сайн, эрчим хүч хэмнэх горим дээр нь ажиллуулж байх;
- Хөргөлт, агааржуулалтын системд хийсэн засвар, үйлчилгээний талаар тогтмол бүртгэл хөтөлж байх;
- Төхөөрөмжийн оператортой тогтмол харилцаатай байж, системийн ерөнхий шинж чанарын талаарх чухал зүйлсийг мэдээлж байх;

*ОЗБ=Озон задалдаг бодис

**ДДНЧ = Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар

БУРУУ

- Хэрэв та аюулгүй ажиллах боломж байхгүй бол бүү хий;
- Зүгээр, сайн ажиллаж байгаа, ямар нэгэн цоорхойгүй системийг өөрчлөх хэрэггүй;
- ОЗБ* болон ДДНЧ** өндөртэй хөргөх бодисыг агаар мандалд гаргаж огт болохгүй;
- ОЗБ эсвэл ДДНЧ өндөртэй хөргөх бодисыг систем цэвэрлэх бодис болгон ашиглах (хамгаалалттай битүү системээс бусад тохиолдолд) эсвэл дулаан солилцогчийн гадаргууг цохиж огт болохгүй;
- Системээс бодисыг (хий, чийг г.м) олон дахин цэвэрлэж гаргахдаа вакуумжсан системд хөргөх бодис шууд оруулж болохгүй бөгөөд үргэлж хүчилтөрөгчгүй, хуурай азотын хийг (OFDN) ашиглаж байх хэрэгтэй;
- Хөргөлт, агааржуулалтын системийг хөргөх бодисын зориулалтын хэмжээг мэдэлгүйгээр дур мэдэн цэнэглэж, дүүргэж болохгүй;
- Бодис юүлэх зориулалтгүй, гэрчилгээгүй, шошгогүй ямар ч бортогыг бодис юүлэхэд ашиглаж болохгүй;
- Бодис юүлэх нэг бортогонд өөр өөр төрлийн бодис хольж хийж болохгүй;
- ДДНЧ багатай хөргөх бодис (нүүрсүстөрөгч/НС гэх мэт) ашиглах зориулалттай хөргөлт, агааржуулалтын системийг ГФН/НFC, ГХФН/НСFC, ХФН/CFС ашигладаг болгож буцаан өөрчилж болохгүй;
- Хэрэв багаж хэрэгсэл тань эвдрэл, гэмтэлтэй бол түүгээр ямар нэг ажил хийж болохгүй ба шаардлагатайгаас илүү урттай хөргөх бодис шилжүүлэх хоолой ашиглаж хэрэггүй;

OFDN (Oxygen Free & Dry Nitrogen)=

Хүчилтөрөгчгүй, хуурай азотын хий

